

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 01 дүгээр сард 2 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэн 18 тогтоол баталлаа.

Үүнд: Аймаг орондоо газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, техник тенхологийн шинэчлэл хийж, тогтвортой амжилт гаргасан бүтээлч хамт олныг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэн амжилт гаргасан тариаланчдыг “Улсын тэргүүний тариаланч”, Мал сүргээ өсгөн үржүүлэх ажилд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулсан, малгүй иргэдийг малжуулахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн малчдыг “Улсын сайн малчин”-аар тус тус шагнуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжиллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2015 онд өөрсийн бүрэх эрхийн хүрээнд 7 зорилт, 75 ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталлаа.

Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийг тус сумын уугуул, Монгол Улсын төрийн соёрхолт, хөдөө аж ахуйн ухааны доктор, дэд профессор Раагийн Жавзмаагийн нэрэмжит болгохоор шийдвэрлэлээ.

Аймгийн засаг даргын захиалгаар төсөвт тусган гүйцэтгүүлсэн байгаль орчны мэргэжлийн байгууллага “Монголын анчдын нийгэмлэг” төрийн бус байгууллагын 2014 оны ажлын тайланг хэлэлцлээ. Мөн “Сэлэнгэ аймгийн агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө”-г Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт үүрэг болголоо.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны тодотгосон төсвийг баталсантай холбогдуулан аймгийн 2015 оны төсөвт тодотгол хийх шаардлага гарсан тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII хуралдааныг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэлээ.

Сүхбаатар сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Мөнх амин үг Баптист Сэлэнгэ” хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

Эрхэлсэн салбартаа хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргасан Баянгол сумын иргэн Л.Жалхарыг гавъяат механикжуулагч, Хушаат сумын иргэн Б.Пүрэвсүрэнг хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор, Ч.Пүрэвсүрэнг хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжав Сайхан сумын Хөтөл хотын өвөлжилтийн байдал, “Гавшгай ус” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Орхон, Орхонтуул сумдын малчидтай уулзаж сүүлийн жилүүдэд төрөөс малчдын талаар баримталж буй бодлого шийдвэр, малын хөлийн татварын талаар санал солилцож, малчин иргэдийн саналыг сонслоо.

Тайлант сард Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих иргэний зөвлөлийн анхдугаар хуралдаан боллоо. Тус хуралдаанаар Иргэний зөвлөлийн хуралдааны нийтлэг дэг, 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг баталж, Цагдаагийн газрын 2014 оны ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж өглөө.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Уул уурхайн яам, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүний эрх хөгжлийн төв, АНУ-ын Азийн сан, хамтран “Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг бичил уурхайн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг 2015 оны 1 сарын 15, 16-ны өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгууллаа. Тус сургалтаар бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оролцогч талуудын хүний эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мөн хамтын ажиллагаа, түншлэлийн үйл ажиллагаанд уг арга зүйг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг, дүн шинжилгээ хийх үр чадвар олгоход энэхүү сургалтын зорилго оршиж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр, шинэ "Үндсэн хууль" батлагдсаны 23 жилийн ойг 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Тус ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газар хамтран ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлалцсан, Ардын Их Хурлын депутатуудад хүндэтгэл үзүүлж, уулзалт ярилцлага зохион байгууллаа. Уулзалт ярилцлаганд Ардын Их Хурлын депутат Д.Тангад, М.Доржсүрэн, Н.Дэлгэрмөрөн, Ж.Бямбаноров, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан Х.Жавхлан, О.Буянтогтох, Аймгийн Засаг даргаар ажиллаж байсан И.Нямбуу, С.Алтангэрэл нарын хүмүүс урилгаар оролцож, дурсамжаасаа хуваалцлаа. Мөн аймгийн Засаг дарга байсан Ж.Бямбаноровын "Сэлэнгэ аймгийн Үндсэн хууль тогтоогчид, хэрэгжүүлэгчид" номын нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2014 оны А/443 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд 2014 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогын ажлыг зохион байгууллаа. Сэлэнгэ аймаг энэ онд 1471184 толгой мал тоолууллаа. Энэ нь өмнөх оноос 156988 толгойгоор өссөн дүнтэй байна. Сүргийн бүтцээр тэмээ 506, адуу 79759, үхэр 196563, хонь 698465, ямаа 495891 тоологдсон байна. Нийт малын 5.4 хувийг адуу, 13.3 хувийг үхэр, 47.4 хувийг хонь, 33.7 хувийг ямаа эзэлж байна. Аймгийн хэмжээнд Орхонтуул суманд хамгийн их буюу 207798 толгой, Сүхбаатар суманд хамгийн цөөн буюу 17843 толгой мал өвөлжиж байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгонд төрсөн Чимэдсэнгээгийн Мөнгөндалай хэл, яриа сонсголын бэрхшээлтэй иргэн, Аав, ээж, ах дүүгээсээ хар багаасаа өнчрөн үлдсэн ч 29-р сургууль, Техникийн коллежийг цахилгаанчны мэргэжлээр төгсөн, мэргэжлээрээ 2 жил ажиллаж байгаад өөрийн сонирхол хүсэл эрмэлзлэлээ даган дугуйн спортоор хичээллэх болжээ. Тэрээр хүсэл тэмүүлэл нь түүнийг Монгол орноо тойрох аялалд урин дуудаж, бүгчим халуун, усан бороо, тэсгэм хүйтэн 167 хоногт 15 аймгийн 210 гаруй сумаар орж, 6200 км замыг ганцаараа явж туулсан байна. Эр зориг гарган 6200 км замыг туулж чадсан нутгийнхаа хүүг аймгийн Засаг дарга С.Бүрэнбат хүлээн авч уулзаж, Засаг даргын “Жуух бичиг” болон мөнгөн урамшууллаар урамшууллаа. Мөн тэр дэлхийг дугуйгаар тойрох хүсэл зоригийг өмнөө тавиад байгаагаа аймгийн даргад танилцуулж, түүний энэхүү том мөрөөдлийг ажил хэрэг болгоход аймгийн зүгээс дэмжин ажиллана гэдгээ хэллээ.

Монголын Үндэсний Олимпийн Хорооны ерөнхийлөгч Д.Загдсүрэн тайлант сард манай аймагт ажиллалаа. Тэрээр Сүхбаатар сумын 2 дугаар сургууль, 3 дугаар цэцэрлэг, Сэлэнгэ аймгийн олимпийн зөвлөл, танхимуудын үйл ажиллагаатай танилцаж, олимпийн танхимын үйл ажиллагааг идэвхитэй сайн ажиллуулж байгаа зарим удирдлагуудыг Монголын Үндэсний Олимпийн Хорооны шагналаар шагналаа.

Тайлант сард аймгийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар хамтран аймгийн хаврын хэрэгцээт нөөцийн махыг бэлтгэх, үнийн хэт өсөлтийг хязгаарлах, хямд үнэтэй махыг зах зээлд нийлүүлэх зорилгоор 10.3 тн

үхэр, хонь, ямааны махыг бэлтгэж Њүеүí ā̄ ĳēē÷ēēā̄yú í íª ÀÀÒ Ā-úí õ° ðā̄ èòòyé махны зооринд хүлээн авч, хавар худалдаанд гаргахаар нөөцлөллөө.

Онцгой байдлын газар:

Тус аймгийн Баруунбүрэн суманд мал амьтны гоц халдварт Хорт салст халуурал өвчин гарсантай холбогдуулж, нутгийн захиргааны байгууллага, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, шуурхай удирдлагаар ханган ажиллаж, Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн шуурхай удирдлагын газарт мэдээлэл хүргүүлээ.

Шинэ жил нэгдсэн арга хэмжээний хүрээнд Төрийн захиргааны 10 байгууллага, галын онц аюултай объект 11, үзвэр үйлчилгээ 4, төвлөрсөн зах, худалдааны төв 26, спортын ордон, ресторан, кафе, шөнийн клуб 15, боловсролын байгууллага 12 нийт 75 объект аж ахуйн нэгж байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 179 зөрчил илрүүлж, 14 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгууллаа.

Гэр хорооллын аюулгүй байдал сэдэвт арга хэмжээг Онцгой байдлын газрын аврах гал унтраах 61 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн, орон нутгийн төр захиргааны байгууллага, багийн Засаг дарга нартай хамтран Сайхан сумын Овоот, Дөмбөн, Жимстэй, Ногоон хорооллын зам гарцын байдалд үзлэг хийн 269 айл өрхийн галын аюулгүйн зай, хэмжээ, пийшин, зуух цахилгааны, өвс тэжээлийн галын аюулгүй байдал гэсэн 4 чиглэлээр үзлэг шалгалт зохион байгуулж, 74 зөрчлийг илрүүлж, 20 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгууллаа.

2015 оны 01 дүгээр сард нийт 16 удаагийн объектын гам түймэр гарсгаас 1 гал түймэр мэдээллээр ирж, гал түймрийн улмаас нийт 56775.0 мянган төгрөгийн хохирол учирсан.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Мандал, Сүхбаатар, Алтанбулаг сум Дулаанхаан тосгоны 10 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумдын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84.0 дээш хувийг хангасан 7 худалдаа үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олголоо.

Сүхбаатар, Мандал сумын 2 аж ахуйн нэгж, иргэний 2 нэрийн 5 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторын сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Худалдаа үйлчилгээний 7 аж ахуй нэгж, иргэний хүсэлтийн дагуу 9 нэрийн 12 стандартаар хангах үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 31 жинг баталгаажууллаа.

Айл, өрх, аж ахуйн нэгж байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа Цахилгааны 1 фазын 22 ширхэг цахилгаан тоолуурыг баталгаажуулалтанд хамрууллаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

12-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	15808319,0	17167107,1	108,6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	13112168,0	13530993,0	103,2
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	73 930 478,60	67 440 053,30	91,2
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	20797225,3	18162299,0	87,3
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4 013 570,70	2 874 767,40	71,6
	- Аймгийн авто замын хөрөнгө	421 292,20	411 687,80	97,7

	оруулалт			
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1 261 842,60	1 074 545,00	85,2
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	9 215 881,40	6 634 299,70	72,0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	4 714 432,20	4 714 432,20	100,0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	39 291 963,70	39 284 902,00	100,0
	Ерөнхий боловсролын сургууль	20 969 361,30	20 969 361,30	100,0
	Хүүхдийн цэцэрлэг	9 930 413,70	9 930 413,70	100,0
	Эрүүл мэндийн байгууллага	4 381 645,20	4 381 645,20	100,0
	Соёл спорт аялал жуулчлалын байгууллага	3 497 837,30	3 497 837,30	100,0
	Газрын харилцаа кадастрын алба	213 512,40	213 512,40	100,0
	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	299 193,80	292 132,10	97,6
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	6 799 085,10	6 799 085,10	100,0
7	Байгууллагад олгосон тусгай зориулалтын шилжүүлгийн нийт дүн	39 291 963,70	38 960 958,80	99,2
	- Боловсролын салбар	30 899 775,00	30 648 102,30	99,2
	- Эрүүл мэнд	4 381 645,20	4 353 158,20	99,3
	- Соёлын байгууллага	2 840 159,00	2 816 084,20	99,2
	Газрын харилцаа БХБгазарт	213 512,40	210 971,60	98,8
	Хүүхэд гар бүл хөгжлийн хэлтэст	299 193,80	279 002,60	93,3
	- Биеийн тамир спортын байгууллага	657 678,30	653 639,90	99,4
8	Аймгийн нийт нөөц хөрөнгө гүйцэтгэл	871 303,10	845 164,00	97,0
9	Үүнээс Аймгийн Засаг даргын нөөц	612 846,60	566 706,40	92,5

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 12 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 108.6 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 98.5 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 72.0 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.2 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 92.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2014 оны 12-р сар	2015 оны 1-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	1100-1200	1100-1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2100	1800
5	Цагаан будаа	1 кг	2200-2400	2200-2400
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	6500	7500
7	Үхрийн мах	1 кг	7000	8500
8	Адууны мах	1 кг	6000	7000

9	Ямааны мах	1 кг	5800	6500
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	6500	7500
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	1000	1100
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	1100	1200
15	Хорхой ааруул	1 кг	10000	10000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4200
18	Өндөг	ш	330	350
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3300	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг	800	800
24	Лууван	1 кг	800	1000
25	Манжин	1 кг	800	1000
26	Байцаа	1 кг	700	800
27	Сонгино	1 кг	1000-1500	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3500	3200-4000
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	2100-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Байгаль орчны газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад Төрийн архивын тасгаас архивын ажлын талаарх заавар зөвлөгөө өгч, хилийн цэргийн 0101 дүгээр ангийн ажилтнуудад баримт бичгийн стандартын талаар сургалт зохион байгууллаа.

Мастер хувиас ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд Мод боловсруулах комбинатын хөмрөгийн 64 хадгаламжийн нэгжийн 11920 хуудас баримтаар Photoshop програм ашиглан ашиглалтын хувь үүсгэсэн. Мөн хөмрөгийн 18 хадгаламжийн нэгжийн 3302 хуудсыг AMS програмд шивлээ.

Иж бүрэн нягтлан шалгалт хийх ажлын хүрээнд Худалдаа бэлтгэлийн удирдах газрын 1978-1981 оны 44 хадгаламжийн нэгж, аймгийн Нэгдсэн музейн 1970-2007 оны 60 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийлээ.

Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 99, эхийн одонгийн лавалгаа 2, цалингийн тодорхойлолт 1, магадлагаа 37, тодорхойлолт 14-ийг гаргаж үйлчилсэн.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 21 даатгуулагчдад 19.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулинд хамрагдсан 2015 оны 01 сарын 01-нээс тэтгэврээ шинээр тогтоолгох, нэмэгдүүлэх иргэдийн нэмэгдлийг хийж ажиллалаа.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2014 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 821 хүн байсан бол 35 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 15 ажлын байранд 10 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 46 иргэн хасагдаж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 800 боллоо.

Монгол Улсын шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 23 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс хууль сурталчлах ажлын хүрээнд ажилтан, албан хаагчдад аймгийн нийт сумдын хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтнуудад цахим хэлбэрээр сургалт хийж, хөгжөөнт цэнгээнт “АХА” тэмцээн зохион байгууллаа.

Сүхбаатар сумын 2014 онд “Сум хөгжүүлэх сан”-ийн эх үүсвэрээр зориулалт бусаар олгосон 35 зээлдэгчийн зээлийг эргүүлэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

6. Хүүхэд залуучуудын талаар:

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсээс хараа хяналтгүй, асрамж халамж, хориход байгаа хүүхдийн судалгааг гаргалаа. Судалгаагаар хараа хяналтгүй 15, асрамжийн газар 3, хорих газарт 2, нийт 20 хүүхэд бүртгэгдлээ.

Аймгийн хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлах, тэдний оюун ухаан, авьяас чадвар, эмх цэгцтэй, хурдан сэтгэн бодох үйл ажиллагааг хөгжүүлэх, ирээдүйн мастеруудыг бэлтгэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “ЦОДГОР ХҮҮ-2015” тэмцээнийг 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 3 насны ангиллаар амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 12 сумын нийт 146 тамирчин оролцож өөрсдийн авьяас чадвар, оюун ухаанаа сорин өрсөлдөж аваргаа тодрууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

НҮеэҮҮ АҮ АЭИ ААН 1990 ИИИИ ОИ ЕӨ ОёҢ, АЭИ АЭИ НАЭИ И АЭ-И ААД Ø АЭААДНАИ И АЭ-АҮИ ААЭҮИ ООДØ ЕААҮА ҮИ ОҮОАҮИ ИИ АИ ЕА ОИ ИД АҮЕОАҮА нийт НОИ УИ 47 малчны материал хүлээн авч, ОҮАЭҮЕОҮИ А ИДООЕАӨАА АҮЕҮИ АИ ЕА ИА ААЭИ А. Ү ЖИ ЕЕ дотор Монгол улсын “Гавъяат малчин” цолоор шагнагдсан Баруунбүрэн сумын И АЭ-ЕИ АИ ҮИ НЖДҮИ АЭИ И АӨАӨЕАЭ АИ ЕИ ОёҢ, АЭИ АЭИ НАЭИ И АЭ-ЕИ ОИ ЕИ ИД Ø АА АААНАИ И АЭ-ЕА И ДАААЭАА РИ .

И ИИ А Э ОёҢУИ ЧАНАЭЭИ ААДҮИ 2009 ИИУ 70-р тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин”-У АИ ЕЦИ Э ОАИ ААНАИ 5 И АЭ-И У И АӨАӨЕАЭ ОҮИ АЭӨ-Ø ЕИ АЭАҮ АЭЕА АЭИ АЭИ ЧАНАА ААДАҮИ Ч° АЭ° Э, ИДАҮАЭЭИ Т° Э° Э° А-АЭЭИ ООДӨҮИ ОҮДААААЭА-АЭЭИ ООДӨААД ООҢ ООҢ ОҮЕҮӨОААЭҮИ ААДӨОӨЕА ООААААИ А И У ОЖИ Н, О° А° АААДӨЭИ ҮАИ АИ А ОДАААЭНҮИ .

АЭИ АЭИ И АЭ АААДӨЭИ ° А° ЭАЭӨДӨЭИ ААЭАЭҮИ ОАЭААД НОИ АААН 7 ОИ ИИ А ААД И ҮАҮҮ АА- ОИ ЕАИ ААИ О АДАА ОҮИ АҮҮА АА- ААЭЕААЭ ААЭИ А. Ү ЖИ ЕЕ АИ ОИ Д АЭИ АЭИ И° О° А ААЭАА ° АН, ОҮАҮҮЕЕАА ° А° ЭАЭӨДӨЭИ ААЭААЭ ОЖИ АҮД- АИ ЕЦИ Ø АЖЕ НОИ АҮИ ЧАӨЕАЭАА ЖИ АҮНЭҮИ ОҮИ А ЖИ ҮҮД И ЕА ОИ ИД Ø ЕЕАААДӨҮҮА ААЭИ А. АЭИ АЭИ И АЭ ° А° ЭАЭӨ АИ ЕИ ОАА ААЭИ ААЭҮИ ОАЭААДХ И ҮАҮҮЕЕЕАА ИИ А ЭҮИ ЖИ АҮНИ ЕЕ олон нийтийн телевиз АИ ЕИ Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээллээ.

1800 кг адууны махны 15 дээж, үхрийн 12180 кг махны 87 дээж, хонины 3360 кг махны 112 дээж, ямааны 680 кг махны 34 дээж, тэмээний 360 кг махны 6 дээж, сүүний 5 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж баталгаажууллаа.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Газрын харилцааны талаар:

“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлыг цэгцлэх ажлын хүрээнд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас төслийг гүйцэтгэгч “Сетсюрвэй” ХХК-тай хамтарч Жавхлант суманд ажиллалаа. Ажлын явцад сумын хэмжээний нийт 987 нэгж талбарын хувийн хэрэгийн бүрдүүлэлтэй дахин танилцаж, нийт төмс хүнсний ногооны 259 нэгж талбарын эрх зүйн актын тулгалтыг хийж кадастрын зурагт орсон 160 нэгж талбараас 33 нэгж талбарт зөрчил гарснаас 22 нэгж талбар нь захирамжийн дугаар ашиглаж бичсэн зөрчил, 97 нэгж талбар кадастрын зурагт огт ороогүйгээс 20 нэгж талбар нь захирамжийн дугаар ашиглаж бичсэн зөрчлүүд гарч байна.

Аймгийн Засаг даргын 3 захирамжаар иргэний одоо эзэмшиж байгаа хашааны газраа өмчлөх хүсэлт гаргасан 10 иргэнд 12439 м² буюу 35746.2 мянган төгрөг, шинээр 9 иргэнд 6291 м² буюу 15727.5 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг тус тус гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүйгээр өмчлүүлж, өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар дундаа өмчилсөн иргэдийн хэлцлийг үндэслэн нийт 6 иргэний 7304 м² хэмжээтэй 27390.0 мянган төгрөгийн үнэ бүхий газрын өмчлөх эрхийг хэвээр үлдээж, 12 иргэнийг хамтран өмчлөгчөөс хасч хууль тогтоомжинд заасны дагуу газар өмчлөх эрхийг нээж өглөө.

Сүхбаатар сумын иргэдээс газар өмчилж авсан нийт 25, Алтанбулаг сумын Засаг даргын захирамжаар газар өмчилж авсан нийт 9 иргэнд газар өмчлөлийн материалыг бүрдүүлэн өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Түшиг сум Редхил Монголия ХХК-ийн Улаан овоогийн нүүрсний уурхайн 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний ажлын даалгаврыг боловсруулж байгаа ба уг ажил дуусаагүй 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зүүнбүрэн сумын Хүүхэд залуучуудын спорт талбай, цэцэрлэгт хүрээлэн, Мандал сумын “НИК” ХХК-ийн шатахуун түгээх станцын шинэчлэлийн зураг төсвийг хяналаа.

Мандал суманд баригдсан “НИК” ХХК-ийн шатахуун түгээх станцын барилга, Сайхан сумын Номгон тосгонд баригдсан “Тэс петролиум” ХХК-ийн шатахуун түгээх станцын барилга дээр тус тус улсын комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авлаа.

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилга дээр хэмжилт хийж засварын ажлын зураг төсөв хийхээр шийдвэрлэлээ.

3. Байгаль орчны талаар:

Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг санхүүжүүлэх, хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгууллаа.

Жавхлант сумын түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газар, Хүдэр сумын “Ургамал дөрөө” ХХК-иас ирүүлсэн төсөл, Зүүнбүрэн суманд эмчилгээ сувилал, аялал жуулчлалын зориулалтаар дуудлага худалдаанд орсон газар түүнийг эзэмшигч “Энх уламжлал” аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх талаар зөвлөгөө өглөө.

2015 оны 01 дүгээр сарын 4, 14, 17-нд нийт нутгаар, 12, 15, 18-нд өмнөд хэсгээр 0,0-4,0 мм цас орж, агаарын температур 1 дүгээр арав хоногт шөнөдөө 25-30 градус, өдөртөө 10-15 градус хүйтэн байлаа, 4-нд өдөртөө бага зэрэг дулаарч

4-8 градус хүйтэн байв. 2 дугаар арав хоногт шөнөдөө 26-31 градус, өдөртөө 12-17 градус хүйтэн байлаа.

Цасан бүрхүүлийн бүрхэц, зузаан 2-р арав хоногт Зүүнбүрэн суманд 23см, цасны нягт 0.12 г/см³. Бугант тосгонд 25 см, цасны нягт 0.19 г/см³ Түшиг, Цагааннуур, Сүхбаатар, Хушаат сумдын нутгаар цасны зузаан 17-18 см, цасны нягт 0.13-0.21 г/ см³ бусад сумдын нутгаар цасны зузаан 4-14 см, цасны нягт 0.10– 0.27 г/см³, хунгар газартаа цасны зузаан 19-47 см байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлд ихэнх сумдын нутгаар малд нэмэгдэл тэжээл өгөх ажил явагдаж байна. Цаг агаарын байдал энэ арав хоногт тохиромжтой байгаа ч Зүүнбүрэн, Бугант, Сүхбаатар, Хушаат, Баянгол сумдын нутгаар цас их орж, цасны нягт ихсэж байгаагаас өвөлжилт хүндрэх төлөвтэй байна.

Долоо.Сум орон нутгийн талаар:

1.Баянгол сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 25 худалдаа үйлчилгээний салбарын үйл ажиллагаатай танилцан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Сумын Засаг даргын 2014 оны А/309 тоот захирамжаар сумын цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд 16-17 насны идэрчүүд, 18-50 насны эрчүүд, бэлтгэл офицерууд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг бүрэн хамруулах ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.

Тус сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч, БШУ-ны ҮЭХ-ны тэргүүн Ж.Батзориг нь физикийн хичээлд ашиглагдах 12653.0 мянган төгрөгийн, химийн хичээлд ашиглагдах 5046.8 төгрөгийн туршилтын багаж, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, хичээлийн ширээ сандал 9190.0 мянган төгрөг, нийт 26889.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Тус сумын эрүүл мэндийн төв нь 2014 онд зарлагдсан “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Эх хүүхдэд ээлтэй сум” шалгаруулах болзолт уралдаанд тэргүүн байр эзэлсэн амжилттай байна.

2.Ерөө сум:

Тус сумын эрүүл мэндийн төв, Багийн Засаг дарга нар хамтран 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэр болох Хандгайт, Буйлааст, Бага Буурагчин, Хонгорын нуруу зэрэг газруудаар явж малчдын өвөлжилттэй танилцлаа. Өвөлжилтийн бэлтгэл байдал сайн, мал тарга тэвээрэг сайн байна.

Сумын хэмжээнд айл өрхийн болон, суурин хүн амын тоог гарган аймгийн статистикийн хэлтэст хүргүүллээ. 2014 оын жилийн эцсээр Ерөө сумын нийт суурин хүн амын тоо 6578, нийт 1801 өрх тоологдлоо. Гадаад оронд 180 хоногоос дээш хугацаанд оршин суугаа 24 иргэн байна.

Ахмад настны талаарх төр засгийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, алжаал ядаргааг тайлах зорилгоор тус сумын ерөнхий боловсролын сургууль, “ДООЛТ” ХХК-тай хамтран Ерөө сумын ахмадын дунд “Хөдөлье-хөлсөө гаргая, инээе-элгээ баярлуулъя” хөгжөөнт цэнгүүнийг зохион байгууллаа.

3.Зүүнбүрэн сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оныг “Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, зарласан жилийн хүрээнд 8 зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж эхэллээ.

Түшиг сумын Улаан-Овоогийн нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулж буй “Ред хилл Монголиа” ХХК-тай тус сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээ байгуулан иргэдэд 800 тн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр нийлүүллээ.

Сумын Засаг даргын Тамгын газар 2014 оны 12 дугаар сарын 05-наас 2015 оны 01 дүгээр сарын 15-ны хооронд “Архигүй эрүүл орчин” аян зарлан уриалга гаргаж төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн ажиллалаа.

4.Мандал сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн судалгааг үндэслэн тухайн гэр бүлийн нөхцөл байдал, ахуй амьдралыг судалж, гэр бүлд хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийлэл байгаа эсэхийг олж илрүүлж, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор зорилтод бүлгийн гэрээр айлчлах аргачлалыг хэрэгжүүлж эхлээд байна.

Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн эмнэлэг, Дэлхийн зон олон улсын байгууллага хамтран Хүүхэд хамгааллын нэг эд эс болсон өсвөр насны охидыг эрт жирэмсэлтээс урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 10-12 ангийн нийт 360 охид, хөвгүүдийг хамрууллаа.

Глобал-комиунитис ОУБ-тай хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй төмс хүнсний ногоо сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүлэг хоршоодын дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 бүлгийн 45 гишүүн оролцож, 2015 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөлөө.

5.Орхон сум:

Энэ сард 2014 оны жилийн эцсийн тайлан мэдээ, Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн тайланг хугацаанд нь хуваарийн дагуу гаргаж холбогдох газарт нь хүргүүлээ.

Өвөл цагийн Соёл хүмүүжлийн ажлын хүрээнд сумын Соёлын төвөөс зохион байгуулсан “Байгууллага сурталчилах 7 хоног” арга хэмжээг тус сумын Засаг даргын Тамгын газар нь энэ сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээ, спортын 3 төрлийн тэмцээнийг тус тус зохион байгуулан ажиллалаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, “Байгаль орчин аюулгүй байдлын төв” төрийн бус байгууллагатай хамтран Байгаль орчин бохирдуулахгүй, хүний эрүүл мэндэд хоргүй технологи орон нутгийн алтны бичил уурхайд хэрхэн нэвтэрч байгаа талаар сургалт зохион байгуулж гарын авлага тараалаа.

6.Сант сум:

2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчдын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, зорилгоор долоо хоногийн Даваа гариг бүр тус сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын шуурхай хуралдаан хийж эхэллээ.

2015 оны 01 дүгээр сарын 23-нд тус сумын Ивэн багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдаж 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг багийн иргэдэд тавьж, сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд “Байгаль хамгаалал”, “Нийгмийн халамжийн бодлого”, “Эрүүл мэндийн даатгал”, “Сайн дурын даатгал”, “Тэтгэврийн Ко бренд карт”, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүд болон сум хөгжүүлэх сан, 2014 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл хийлээ.

Тайлант сард сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2014-2021 он хүртэлх нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сант сум нь аймгийн 2014 онд шинээр хамгийн олон ажлын байр бий болгон тогтвортой хадгалж, жижиг дунд үйлдвэр өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн “Шилдэг сум”-аар шалгарлаа.

7.Сүхбаатар сум:

Гудамж, талбай, олон нийтийн газар, архидан согтуурах, хулгайлах, танхай, дээрэм, булаалтын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл

“Нийтийн эргүүл”-ийг ажиллуулах тухай тус сумын Засаг даргын захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ахлагч нартай уулзалт зохион байгуулж 2015 онд хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцлоо.

Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг идэвхжүүлэх зорилгоор аймгийн Нэг цонхны үйлчилгээ, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран өдөр бүрийн 11:00-11:15 цагийн хооронд дасгал хөдөлгөөн хийж эхлээд байна.

Тус сумын тохижилт үйлчилгээний газар нь 2014 оны 12 дугаар сарын 25-аас 2015 оны 01 дүгээр сарын 25-ны хүртэл нийт 41 орон тоотойгоор ажлын болон амралтын өдрүүдэд ажиллаж 218 рейсээр 730 тн хог хаягдлыг зөөн тээвэрлэж булж устгалаа.

8.Алтанбулаг сум:

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон 2015 оны 01 сарын 10-ны өдөр Алтанбулаг суманд ирж туршлага судлан хамтын ажиллагааг өргөжүүлэхээр уулзалт ярилцлага зохион байгуулж, сум орон нутагтай танилцлаа.

2015 оны 01 дүгээр сарын 13-нд сумын Цагдаагийн хэсэг болон, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн гэрээт объект хамгаалах хэсгийн 2014 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан тавих арга хэмжээг сумын соёлын төвд зохион байгууллаа.

9.Цагааннуур сум:

Тайлант 10-д тус сумын Засаг даргын Тамгын газрас төр, төсвийн байгууллага аж ахуйн нэгж агаарын хөдөлгөөнийг дарга эрхлэгч нарын өмчлөх ажиллагааг иргэдэд ойлгох арга хэмжээг сумын удирдлагуудад үргэлжлүүлж байна.

2015 оны 01 дүгээр сарын 13-нд сумын Цагдаагийн хэсэг болон, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн гэрээт объект хамгаалах хэсгийн 2014 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан тавих арга хэмжээг сумын соёлын төвд зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны 01 сарын 07-ны өдөр сум дундын ойн ангь, байгаль хамгаалагч нар, ойн нөхөрлөлийн тэргүүлэгч гишүүдтэй уулзаёт зохион байгууллаа. Уулзалтаар хамтын эзэмшлийн ойн нөхөрлөлүүдийн гэрээ шинэчлэх, мөн менежментийн төлөвлөгөө боловсруулах, асуудлуудыг хэлэлцэж, цэвэрлэгээний огтлолтоор түлшний мод бэлтгэх хувиарлалт хийлээ.

10.Хушаат сум:

Тус сумын нутгаар талдаа 30-35 см, гуу жалганд 70-120 см цас шууран хунгарлаж мал бэлчээрлэхэд хүндрэлтэй болсон бөгөөд нутгийн баруун болон баруун хойд хэсэг болох Артойлбо, Дэрвэдэг, Арсүүж, Ар Урт, Бор толгойд нийт 48 малчин өрхийн 18330 толгой мал өвөлжиж байна. Сумын Засаг даргын Тамгын газраас трактор, автомашин, хүн хүч гарган Ар Уртын чиглэлд цасыг ярж зам гаргасан боловч дахин шуурч замыг хаалаа. Сумын Засаг даргын Зөвлөлийн ээлжит хурлаар өвөлжилтийн нөхцөл байдлын тухай, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцэн сумын өвсний фондноос болон Дархан уул аймгийн гурил тэжээлийн үйлдвэртэй гэрээ байгуулан хивэг татан авч малчдад нийлүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, “Клайм” олон улсын тусламжийн байгууллагатай хамтран нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай байгаа зорилтот бүлгийн 18 өрхийн 94 гишүүнд 2.0 сая төгрөгийн хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Сумын газар тариалангийн үйлдвэрлэлийн 2015 оны төлөвлөгөөг гарган, 14238 га үр тариа тариалж 19425 тн ургац авч 6976 га-д уринш хийхээр төлөвлөлөө.

11.Хүдэр сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны үлдэгдэл модыг бэлтгэж дуусаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэдээр бэлтгүүлэн дуусгаж, 2014 оны мод бэлтгэлийн гүйцэтгэлийг тооцон гаргалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан 2015 онд Хүдэр суманд бэлтгэх үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний болон түлээний модыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн иргэд, ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдэд хувиарлалаа.

Ойн дагалдах баялагийг хамгаалах, зохистой ашиглах журам болон сумын Засаг даргын Захирамжаар 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг гарч Хэрц, Моностойн чиглэлд нийт 5 хоног ажиллаж, Самар түүж байсан иргэд самрын хальс шатаан унтраалгүй явсан байсныг илрүүлж, бүрэн унтраалаа. Тус ажлын хүрээнд гадны аймаг сум болон сум орон нутгийн 240 ард иргэдэд санамж тарааж, хог хаягдлын тухай хуулиар мэдээлэл хийлээ.

12.Шаамар сум:

Тус сумын алслагдсан айл өрхөд төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, өвөлжилтийн бэлтгэл нөөцийг судлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөмж өгөх зорилгоор сумын удирдлагууд, багийн Засаг дарга нар, хэсгийн төлөөлөгч цагдаа хамтран Дэлгэрхаан, Охиндий багуудын нийт 56 өрхөд хүрч ажиллалаа.

Хаврын тэргүүн сарын шинийн нэгний сар шинийн баярыг тохиолдуулан сумын хэмжээнд ажиллаж амьдарч буй харьяалалгүй болон байгууллага нь татан буугдсан бусад газраас шилжин ирсэн өндөр настнуудын судалгааг гаргаж 2015 оны 01 сарын 24-ний өдөр хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР